



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ГАЗАР**



# **Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн МЭДЭЭЛЭЛ**



**2023 оны 12 дугаар сарын байдлаар**

**Мөрөн сум**

## ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

### ТӨРӨЛТ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 12 сарын байдлаар 2167 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 124 тохиолдол буюу 5,4%-иар буурсан байна. Төрөлт Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Рэнчинлхүмбэ,Тариалан, Тосонцэнгэл, Ханх, Цагаан-Уул, Цагааннуур сумдад өсч, бусад сумдад өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Нийт төрсөн эхчүүдээс 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан хамрагдалтын хувь 72,1% байна.



### ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 12 сарын байдлаар нийт 2179 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 120 тохиолдолоор буурсан байна. Амьд төрсөн хүүхдийн 2.9 хувь /64/ нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн байна. Төрөөд нэг цагийн дотор хөхөө амласан хүүхдийн хувь 96.9 хувь байна. 5 хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 2023 оны эхний 12 сард нийт 62632 хүүхэд жинлэж, жинлэсэн хүүхдийн 0.1 хувь нь туранхай, 0,1 хувь нь тураалтай, 0,1 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. 56.0 хувь нь Д амин дэм, 6.3 хувь нь олон найрлагат бичил тэжээл, А амин дэмийг 20792 хүүхэд хэрэглэсэн байна.

## НЯЛХАСЫН ЭНДЭГДЭЛ

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 12 сарын байдлаар нялхсын эндэгдлийн 23 тохиолдол бүртгэгдсэн нь 2022 оны мөн үеэс 14 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөнд 10.6 ногдож байна. Нялхсын эндэгдлийн 39.1 хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа бөгөөд 1000 амьд төрөлтөд 4.1 байна. Нийт 12 тохиолдол буюу 65.2 хувь нь эмнэлэгт эндсэн бөгөөд 11 нь эрэгтэй хүүхэд байна.


Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл:




## 1-5 НАС ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

2023 оны эхний 12 сарын байдлаар 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор өссөн байна. 1000 амьд төрөлтөнд 6.0 ногдож байна. Хүүхдийн эндэгдлийг оношоор нь авч үзвэл хавдар 2, мэдрэлийн тогтолцооны эмгэг 1, амьсгалын тогтолцооны эмгэг 3, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 1, төрөлхийн гаж хөгжил 2, осол гэмтлийн шалтгаант нас баралтын 4 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.


### 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, бодит тоогоор



### 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 2022 оны байдлаар




### 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, 2023 оны байдлаар



## НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ

2023 оны эхний 12 сарын байдлаар 738 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 тохиолдолоор буурсан байна. Нийт нас баралтын 18,7 хувь нь эмнэлэгт нас барсан ба үүнээс 38,4 хувь нь хоног болоогүй нас баралт байна. Осол гэмтлийн нас баралт 87 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 38 тохиолдолоор буурсан, нийт нас баралтын 11,8 хувийг эзэлж, 10000 хүн амд 6,3 ногдож байна. Хорт хавдрын нас баралт 213 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 20 тохиолдлоор өсч, нийт нас баралтын 28,9 хувийг эзэлж, 10000 хүн амд 15,5 ногдож байна.



Нийт нас баралтын тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/



1. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 24.2
2. Хавдар-15.5
3. Гадны шалтгаант өвчлөл- 11.8
4. Хоол боловсруулах тогтолцооны эмгэг-2,0
5. Амьсгалын тогтолцооны өвчин-1.9



Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 12 сарын байдлаар нийт эдийн шинжилгээ 1243, эсийн шинжилгээ 6617 хийгдсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 85 нас баралт буюу 45.9% эмгэг судлалын задлан шинжилгээ хийгдэж үндсэн оношийн зөрүү бүртгэгдээгүй байна. Задлан шинжилгээ хийгдээгүй нас баралт 46 тохиолдол байна.

### АМБУЛАТОРИ СТАЦИОНАРИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 12 сарын байдлаар амбулаторид нийт 619746 үзлэг хийгдсэнээс 41.6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 47.1 хувийг өвчний учир амбулаторид, 4.2 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, 5.2 хувийг гэрийн идэвхитэй үзлэг, 1.9 хувийг гэрийн дуудлагын үзлэг эзэлж байна.



### ЖИРЭМСЭНИЙ ХЯНАЛТ

Шинээр хяналтанд авсан нийт 1957 жирэмсэн эмэгтэйчүүдээс 92,8 хувь нь жирэмсний эрт үедээ хяналтанд хамрагдсан байна. Цусны шинжилгээнд 96,1 хувь нь хамрагдаж, 1.7 хувь нь цус багатай гарсан байна. Эхний 12 сарын байдлаар жирэмсний хяналтанд шинээр орсон эхчүүдээс трихомониаз, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 91.8 хувийг, тэмбүү болон ХДХВ илрүүлэх шинжилгээнд 95.0 хувийг тус тус хамруулж заг хүйтэн-30 трихомониаз-9, тэмбүү-20 тохиолдлыг тус тус бүртгэн эмчилсэн байна.

Жирэмсэний эрт хяналтын хувь,  
2023 оны эхний 12 сарын байдлаар



## ХАЛДВАРТ БУС ӨВЧИН

2023 оны эхний 12 сарын байдлаар халдварт бус өвчлөл 140138 тохиолдол бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үеэс 6210 тохиолдлоор өссөн байна. 10000 хүн амд 10169.8 байгаа ба осол гэмтлийн өвчлөл 1513 бүртгэгдэж, нийт халдварт бус өвчний 1.1 хувийг эзэлж, 10000 хүн амд 109.8 байна.

Амбулаторийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан: /10000 хүн амд/

1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин- 2135.1
2. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин- 2096.6
3. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин-1943.1
4. Шээс бэлгэсийн тогтолцооны эмгэг-1037.2
5. Мэдрэлийн тогтолцооны өвчин-817.4


Стационарт нийт 30336 хүн хэвтэж эмчлүүлж, 203307 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 6.7, орны эргэлт 32.3, орны фонд ашиглалт 216.7 фонд ашиглалтын хувь 65.7 байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 12 сарын байдлаар нийт 18809 түргэн тусламжийн дуудлага хүлээж авч гүйцэтгэснээс 15.9 хувь /2983/ нь алсын дуудлага, 3.5 хувь /658/ нь осол гэмтлийн дуудлага байна. 1 өдөрт дунджаар аймгийн хэмжээнд 52.2 дуудлага, АНЭ 16.2 дуудлага тус тус хүлээн авч гүйцэтгэжээ.


## ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны эхний 12 сарын байдлаар артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 65605 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 74.8 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 43.3% эрэгтэй, 56.7% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 7067 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон артерийн гипертензи 564 буюу 8.0% нь онош баталгаажсан байна. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 45660 хүн анх хамрагдаж, хамрагдвал зохих хүн амын 86.2 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүний 42.4% эрэгтэй, 57.6% нь эмэгтэй байна. Давтан үзлэгт 1953 хүн хамрагдсан ба үүнээс оношлогдсон 53 буюу 2.7% нь онош баталгаажсан байна.


### Эрт илрүүлэг үзлэг хувиар, 2023 оны 12 сарын байдлаар



### Эрт илрүүлэг үзлэг, 2023 оны эхний 12 сарын байдлаар



### Эрт илрүүлэг үзлэгийн хувь, 2023 оны эхний 12 сарын байдлаар





Эрт илрүүлэг үзлэгийн хувь,  
2023 оны эхний 12 сарын байдлаар



## ӨРХИЙН ЭМТ-ИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн ЭМТ нийт үзлэг 120874 байгаа ба үзлэгийн төрлөөр нь авч үзвэл:

- Урьдчилан сэргийлэх үзлэг 54.0 хувь
- Өвчний учир үзлэг 23.4 хувь
- Диспансерийн хяналт 7.4 хувь
- Гэрийн идэвхитэй эргэлт 14.5 хувь
- Гэрийн дуудлага 0.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт бус өвчний 13511 тохиолдол бүртгэгдэж, 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 6.8 хувийг, 5 хүртэлх насны хүүхдийн халварт бус суулгалт 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Шинээр хяналтанд авсан 698 жирэмсэн эмэгтэйдгээс 92.8 хувийг эрт үед нь хяналтанд авч 100 хувийг цусны шинжилгээнд хамруулсан байна.

Нийт 225 нас баралт бүртгэгдсэн ба Аймгийн Нэгдсэн Эмнэлэгт 40 тохиолдол байна. Хорт хавдрын нас баралт 77, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдсэнээс аймгийн нэгдсэн эмнэлэгт 2 тохиолдол бүртгэгдсэн байна.

## ХУВИЙН ЭМНЭЛГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хувийн эмнэлгүүд нийт 34687 үзлэг хийснээс

- Урьдчилан сэргийлэх үзлэг 14.7 хувь
- Диспансерийн хяналт 2.7 хувь
- Өвчний учир үзлэг 82.6 хувийг тус тус эзэлж байна.

Стационариар нийт 8325 хүн хэвтэн эмчлэгдэж, 60244 ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.2 орны эргэлт 27.0 ба орны фонд ашиглалт 195.6, орны фонд ашиглалтын хувь 59.3 байна.

Нийт халдварт бус өвчний 121 тохиолдлоос 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог өвчин 102 тохиолдол бүртгэгдсэн байна.

## ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд эхний 12 сарын байдлаар 1206 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 87.5 ногдож байна. 2022 оны мөн үед 5558 тохиолдол, 10000 хүн амд 406.2 ногдож байжээ. 10000 хүн амд ногдох халдварт өвчний гаралт Алаг-Эрдэнэ /143.8/, Арбулаг /93.9/, Баянзүрх /93.3/ Тосонцэнгэл /145.1/, Төмөрбулаг /92.8/, Цагаан-Үүр /92.9/, Мөрөн /141.2/ суманд аймгийн дунджаас өндөр байна.


Нийт халдварт өвчнөөс БЗХӨ 58.6 хувь, сүрьеэ 5.7 хувь, амьсгалын замын өвчин 18.6 хувь, цусан халдвар 0.9 хувь, гэдэсний халдварт өвчин 10.6, арьс салтстаар халдварлах халдвар 1.0, Зоонозын болон мал амьтнаас хүнд халдварладаг өвчлөл 0,8 хувь, Ковид-19 халдвар 3.8 хувийг тус тус эзэлж байна.

## ЦОЧМОГ ХАЛДВАРТ ӨВЧИН

Нийт цочмог халдварт өвчний 499 тохиолдлоос:

- Сальмонеллэз 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит А 0 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Халдварын гаралтай гастроэнтерит ба суулга 2 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор
- Хачигт рикеттиоз 8 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 8 тохиолдлоор
- Ковид-19 46 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 4258 тохиолдлоор тус тус буурч
- Сүрьеэ 69 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Цусан суулга 66 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 33 тохиолдлоор
- Хоолны хордлого 59 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 50 тохиолдлоор
- Хачигт энцефалит 1 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 1 тохиолдлоор
- Хепатит В 6 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Хепатит С 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор
- Ёлом 12 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 9 тохиолдлоор
- Салхинцэцэг 179 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 118 тохиолдлоор
- Гар хөл амны өвчин 22 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 11 тохиолдлоор
- Улаан-Эсэргэнэ 5 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор тус тус өсч
- Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс халдварт саа, сахаруу, хөхүүл ханиад, татран, менингококкт халдварын өвчлөл бүртгэгдээгүй байна.

Цочмог халдварт өвчин, 2023 оны эхний 12 сарын байдлаар






	Гахайн хавдар	Цусан суулга	Халдвар хепатит А	Халдвар хепатит В	Халдвар хепатит С	Сүрьеэ	Салхинцэцэг	хоолны хордлого	Халдварын гаралтай суулгалт	Ёлом	Гар хөл амны өвчин	Ковид-19	Хачигт рикеттиоз	Хачигт энцефалит	Сальмонеллэз	Улаан-Эсэргэнэ
■ 2023		66		6	5	69	197	59	2	12	22	46	8	1	1	5
■ 2022		33	1	4	3	68	79	9	5	3	11	4304	16		2	


■ 2023 ■ 2022

## ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАМ ШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДОЛ


- 2023 оны эхний 12 сарын байдлаар халдварт өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц 410 тохиолдол мэдээлэгджээ. Үүнээс халууралт тууралт 15.6 хувь (64), цэврүүт тууралт 52.0 хувь (213), цочмог халууралт, цусархаг тууралтат 13.9 хувь (57), цочмог шарлалттай 2,7 хувь (11), цочмог усархаг 1.46 хувь (6), суулгалт хоолны хордлогот халдвар 14.4 хувь (59) тус тус бүртгэгдсэн байна.
- Нийт мэдээлэгдсэн хам шинжийн өвчлөл /бодит тоогоор/



Тууралттай хамшинжийн тохиолдол  
мэдээлэгдсэн долоо хоногоор




Суулгалттай хамшинжийн тохиолдол  
мэдээлэгдсэн долоо хоногоор




**ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН**

2023 оны эхний 12 сарын байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ий 28791 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 2089.4 болсон байна. Харин өнгөрсөн оны мөн үед 28004 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 2046.4 болсон байна.


Томуу, томуу төст өвчин, 10 000 хүн амд




Томуу томуу төст өвчин, долоо хоногор, 2023 он




Томуу, томуу төст өвчин (насны бүлэг, хувиар), 2023 он



АЗЦХХ-ын хэвтэлт (насны бүлэг, хувиар), 2023 он



Томуу, томуу тест өвчин 10000 хүн амд, сумдаар




## БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН


Нийт халдварт өвчний дотор БЗХӨ-ний эзлэх хувь 58.6% (707) тохиолдол байгаа ба өнгөрсөн оны мөн үед 18.4% (1020) тохиолдол бүртгэгдсэнээс:

- Гонококкт халдвар 534 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 264 тохиолдлоор
- Трихомониаз 46 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 18 тохиолдлоор
- Тэмбүү 127 тохиолдол буюу өмнөх оны мөн үеэс 30 тохиолдлоор тус тус буурсан байна.


Бэлгийн замын халдварт өвчин, 2023 оны эхний 12 сарын байдлаар



Бэлгийн замын халдварт өвчин, насны бүлгээр



Бэлгийн замын халдварт өвчин, боловсролын түвшингээр



ХЯНАСАН:

ДҮГНЭЛТ ХИЙСЭН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХ-АЮУШ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН П.БАЯРМАА